

2024 оны Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр

-ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ОЮУТАН-

-ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТАН /КООСЭН/-

-МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН-

Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН ОЮУТАН, ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТАН /КООСЭН/, МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН”-ы бүртгэл эхэллээ.

Энэ жил бүртгэл хүлээн авах болон бүрдүүлэх бичиг, баримтаа ирүүлэхтэй холбоотой зарим өөрчлөлт орсон тул сайтар уншиж танилцана уу. Мөн шинэ төрлийн коронавирусийн халдварын нөхцөл байдлаас хамааран бүртгэлийн хугацаа өөрчлөгдөх, цуцлагдаж болзошгүйг анхаарна уу.

Өмнөх жилээс өөрчлөгдсөн зүйлсийн тухай

| | |
|--------------------------------------|---|
| Бүртгэх болзол, шалгуур: | 3. Бүртгэх болзол, шалгуур гэсэн хэсгийг үзэх.. |
| Бүртгэл хүлээн авах: | Цахимаар хүлээн авна. 2023.05.08 өдрөөс цахим бүртгэл нээгдэнэ. |
| Бүртгэл хүлээн авах хугацаа: | 2023.05.08 (Даваа) 00:00 цагаас 2023.05.14 (Ням) 23:59 цаг хүртэл |
| Бүрдүүлсэн баримтаа ирүүлэх хаяг: | Японы Элчин сайдын яам |
| Бүрдүүлсэн баримтаа ирүүлэх хугацаа: | 2023.05.08 (Даваа) 09:00 цагаас 2023.05.19 (Баасан) 17:45 цаг хүртэл |
| Зөвлөгөө өгөх уулзалт: | 2023.05.10 (Лхагва)-2023.05.12 (Баасан) 14:00 цагаас 17:00 цаг хүртэл Монгол Япон төв, 1-р давхрын хүлээлгийн танхимд |
| Бүртгэлтэй холбоотой лавлах утас: | 99104966 2023.05.08-05.19 хүртэл 09:00-17:00 цаг хүртэл Бусад үед дээрх цагаар 11-320777#124,125 |

1. Хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөр бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх “Application guide” линкээр орж үзнэ үү.


| Хөтөлбөрүүд | Их сургуулийн үндсэн оюутан (Application guide) | Технологийн коллежийн (Коосэн) оюутан (Application guide) (Сонгох боломжтой мэргэжилүүд) | Мэргэжлийн сургуулийн оюутан (Application guide) (Сонгох боломжтой мэргэжилүүд) |
|--|--|--|---|
| Суралцах сургууль | Их сургууль | Технологийн коллеж | Мэргэжлийн сургууль |
| Товч танилцуулга | Их сургуулийн элсэлтийн шалгалтад тэнцсэнээр Японы их сургуульд 4 жил суралцан бакалавр зэрэгтэй болно. | Японы БШУЯ-ны заасан технологийн коллежийн 3-р курсээс шилжин суралцаж, техникийн мэргэжлийн үр чадвар эзэмшинэ. | Японы БШУЯ-ны заасан мэргэжлийн сургуульд элсэн орж, практик болон мэргэжлийн үр чадвар эзэмшинэ. |
| Төгссөний дараа авах боловсролын зэрэг | Бакалавр | Технологийн коллежийн тусгай зэрэг | - |
| Хугацаа | ★Бэлтгэл анги 1 жил Үндсэн анги 4 жил | ★Бэлтгэл анги 1 жил Технологийн коллеж 3 жил | ★Бэлтгэл анги 1 жил Мэргэжлийн сургууль 2 жил |
| Шалгалтын төрөл | 【Нийгмийн ухаан】 Япон хэл Англи хэл Математик 【Байгалийн ухаан А】 Япон хэл Англи хэл Математик Хими Физик 【Байгалийн ухаан В, С】 Япон хэл Англи хэл Математик Хими Биологи | 【D】 Япон хэл Англи хэл Математик Хими 【A, B, C, E, F, G】 Япон хэл Англи хэл Математик Физик 【H】 Япон хэл Англи хэл Математик Хими эсвэл Физик | Япон хэл, Англи хэл, Математик |
| Тэтгэлэг | Тэтгэлгийн хэмжээ: Сар бүр 117,000 иен Тэтгэлэг олгох хугацаа: Сургуульд сурч буй хугацаанд Сургалтын төлбөр, хоёр талын нислэгийн тийзгийг Японы Засгийн газраас хариуцна. | | |

★Бэлтгэл анги:

Оюутнууд эхний 1 жил Японы БШУЯ-наас (Монбүшо) хуваарилсан бэлтгэл сургалтын байгууллагад их сургуульдаа элсэн суралцахад шаардлагатай япон хэлний эрчимт сургалт болон бусад бэлтгэл сургалтад хамрагдана.

Их сургуулийн үндсэн оюутны хувьд бэлтгэл ангиа дүүргэн, Японы БШУЯ-наас хуваарилсан их сургуулийн шалгалтыг өгч, тэнцсэний дараа тухайн сургуульдаа элсэн орно. Оюутны шалгалт өгөх их сургуулиудыг ЭСЯ-наас авсан нэгдүгээр шатны шалгаруулалтын дүн, бэлтгэл ангийн дүн, суралцах мэргэжил, их сургуулийн хүлээн авах хүчин чадал зэргийг харгалзан Японы БШУЯ-наас бэлтгэл сургалтын байгууллага, их сургуультай зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

2. Сонгон шалгаруулах дараалал



3. Бүртгэх болзол, шалгуур

| | |
|------------------------|---|
| Иргэншил | Монгол Улсын иргэн байх |
| Нас | 1999 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр болон түүнээс хойш төрсөн байх |
| Боловсрол | <p>Өргөдөл гаргагч нь доорх аль нэг нөхцөлийг хангасан байна.</p> <ol style="list-style-type: none"> МУ дахь ЕБС-ийн 12-р ангийн сурагч байх; МУ дахь их, дээд сургуулийн 1, 2-р курсийн оюутан байх; МУ дахь технологийн коллежийн /Коосэн/ 3, 4, 5-р курсийн оюутан байх; 2024 оны 3-р сар гэхэд Японы ахлах сургуультай дүйцэх хэмжээний сургуулийн сургалтыг дүүргэх хүн; 12 жилийн сургалтыг дүүргэсэнтэй дүйцэх боловсролын шалгалтад тэнцсэн хүн; |
| Сурлагын дүн | <ol style="list-style-type: none"> 12-р ангийн сурагч Сүүлийн 3 жилийн сурлагын голч онооны дундаж нь GPA 3.5, түүнээс дээш байна. Их, дээд сургууль, технологийн коллежийн оюутан: ЕБС-ийн 10, 11, 12-р анги, түүнтэй дүйцэх сурлагын голч онооны дундаж нь GPA 3.5, түүнээс дээш, мөн их, дээд сургууль, коллежийн төгссөн курс хүртэлх сурлагын голч онооны дундаж нь GPA 3.5, түүнээс дээш байна. <p>*Сурлагын дүнг бусад үнэлгээний аргаар тооцсон бол голч оноо GPA 3.5 түүнээс дээш оноотой дүйцэхүйц байна.</p> |
| Эрүүл мэндийн байдал | Бие, сэтгэцийн хувьд эрүүл байх |
| Японд руу явах хугацаа | <ol style="list-style-type: none"> 4-р сарын элсэлтийн оюутан: 2024.04.01-2024.04.07 өдрүүдэд Япон руу явах боломжтой байх 10-р сарын элсэлтийн оюутан: Хүлээн авах сургуулийн шийдвэрийн дагуу хичээлийн жил эхлэх хугацаанаас өмнөх эсвэл хойших 14 хоногийн дотор сургуулиас заасан хугацаанд Японд очих боломжтой байх; |
| Бусад | <ol style="list-style-type: none"> Японд очих үед цэргийн албан хаагч эсвэл цэргийн байгууллагад ажилладаггүй байх; Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр өмнө нь суралцаж байсан бол суралцсанаас хойш хамгийн багадаа 3 жил, түүнээс дээш хугацаанд судалгааны ажил хийсэн эсвэл ажилласан байх; (Өмнө нь ЯПОН ХЭЛ, ЯПОН СОЁЛЫН СУДЛААЧ ОЮУТАН-ы хөтөлбөрөөр суралцсан оюутан СУДЛААЧ ОЮУТАН-аар бүртгүүлэх бол дээрх болзол хамаарахгүй) Гадаад оюутны статусаар Японы аль нэг их, дээд сургуулийн харьяалалгүй байх, эсвэл суралцах эсэх нь шийдэгдээгүй байх; Тэтгэлэг авах эрхтэй болсноос хойш бусад газраас оюутны тэтгэлэг аваагүй, эсвэл авахаар төлөвлөгөөгүй байх; |

4. Бүртгэл, бүрдүүлэх бичиг баримт

Энэ жил хөтөлбөрийн бүртгэлтэй холбоотой зарим өөрчлөлт орсон тул дараах мэдээлэлтэй танилцан бүртгүүлнэ үү.

【Бүртгэл, бүрдүүлэх бичиг баримтын дараалал】

1. **Цахим хэлбэрээр бүртгэл явуулж**, шалгалт өгөх хүний мэдээллийг хүлээн авна.

Бүртгүүлэх бол доорх холбоосоор орж, мэдээллээ илгээнэ.

/ * * * * / цахим бүртгэлийн холбоос доорх хугацаанд нээгдэх тул тэр үед сайтад тавигдана.

Бүртгэх хугацаа: 2023.05.08 (Даваа) 00:00 цагаас 2023.05.14 (Ням) 23.59 цаг хүртэл байна.

2. Бүртгүүлсний дараагаар **бичиг баримтаа бүрдүүлэн Японы ЭСЯ-нд хаяглан ирүүлнэ.**

Хүснэгт-1 заасны дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж ирүүлнэ.

Зураг-1 заасны дагуу бичиг баримтаа дугтуйлан, зургийн дагуу хаяглан, Японы ЭСЯ-ны төв харуулын байранд авчирч өгнө.

Хүлээн авах хугацаа: 2023.05.08 (Даваа)-2023.05.19 (Баасан) 09.00-17.45 цаг хүртэл байна.

2023.05.10 (Лхагва)-2023.05.12 (Баасан) болох зөвлөгөө өгөх уулзалтын үеэр бүрэн бүрдүүлсэн бичиг баримтыг хүлээн авна.

(Хөдөө орон нутагт оршин суугч болон бичиг баримтаа өгөх хугацаанд эзгүй байх хүний хувьд төлөөний хүнээр дамжуулан авчирч өгөх эсвэл шуудангаар явуулах боломжтой. Шуудангаар ирүүлэхдээ эцсийн хугацаа 19-ний өдрөөр тамгалагдсан баримтыг хүлээн авах бөгөөд хойш тохиолдолд хүлээн авахаас татгалзана.)

Бүрдүүлэх бичиг баримт: (Хүснэгт-1)

| | Бүрдүүлэх бичиг баримт | Эх хувь | хуулбар |
|---|---|--|---------|
| 1 | Өргөдөл /Тогтсон маяг/ Их сургууль / Техникийн коллеж / Мэргэжлийн сургууль | 1 | 1 |
| 2 | Харьяа сургуулийн сурлагын дүнгийн жагсаалт Энэ хичээлийн жилийн хувьд сүүлийн улирлын сурлагын дүнгийн жагсаалтыг ирүүлнэ. 1. 12-р ангийн сурагч: 10, 11, 12-р ангийн сурлагын дүнгийн жагсаалт 2. Их, дээд сургуулийн 1, 2-р курсийн оюутан: 10, 11, 12-р ангийн сурлагын дүнгийн жагсаалт Их, дээд сургуульд элсэн суралцсанаас хойш өргөдөл гаргах хүртэлх үеийн сурлагын дүнгийн жагсаалт 3. Технологийн коллежийн 3, 4, 5-р курсийн оюутан: Технологийн коллежид элсэн суралцсанаас хойш өргөдөл гаргах хүртэлх үеийн сурлагын дүнгийн жагсаалт | 1 -нотариат -орчуулга /англи эсвэл япон хэлээр/ | 1 |
| 3 | Сургууль төгссөн диплом, гэрчилгээ /Төгсөх тухай тодорхойлолт/ * Сургууль төгсөх тухай тодорхойлолтод дараах зүйлсийг тусгана. Суралцагчийн овог нэр, анги, төгсөх хугацаа, сургуулийн захирлын нэр, гарын үсэг, огноо, тамга тэмдгээр баталгаажсан байна. | 1 -нотариат -орчуулга /англи эсвэл япон хэлээр/ | 1 |
| 4 | Анги даасан багш эсвэл сургуулийн захирлын зан байдлын тодорхойлолт /тогтсон маягт байхгүй/ /Жишээ загвар/ | 1 -нотариат -орчуулга /англи эсвэл япон хэлээр/ | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Суралцаж буй сургуулийн тодорхойлолт /Их, дээд сургуульд суралцаж буй бол/ | 1 | 1 |
| 6 | Ерөнхий боловсролын сургууль төгссөнтэй дүйцэх боловсролын гэрчилгээ (Certificate for Students Achieving the Proficiency Level of Upper Secondary School Graduates) /гэрчилгээ байх бол/ | 1 -нотариат -орчуулга /англи эсвэл япон хэлээр// | 1 |
| 7 | Гадаад хэлний шалгалтын онооны гэрчилгээ /япон хэл, англи хэлний шалгалтын онооны гэрчилгээ байх бол/ | | 2 |
| 8 | Цээж зураг /3.5 см ×4.5 см, сүүлийн 6 сарын дотор авхуулсан, эгц өөдөөс харсан, малгайгүй, зургийн ард талд нэрээ бичсэн байх/ | 1 | |

Анхаарах зүйлс:

- Өргөдлийг япон хэл эсвэл англи хэлээр бөглөнө.
- Тодорхойлолт нь байгууллагаас гаргасан албан ёсны бичиг баримт байна.
- Эх хувь нь монгол хэл, бусад гадаад хэлээр байх бүх бичиг баримтаа заавал англи хэл эсвэл япон хэлээр орчуулж, хуулбарын хамт хавсаргана.
- Эх хувийг хувилсан бичиг баримтаа заавал нотариатаар баталгаажуулна.
- ЭСЯ-нд хүлээн авсан бичиг баримтыг буцаан олгохгүй.

Дугтуйг хаяглах: Зураг-1



Санамж:

Дугтуйг ЭСЯ-нд дугтуйг авчирч өгөхдөө харуулын ажилтанд Засгийн газрын тэтгэлэгт оюутнаар бүртгүүлж, бүрдүүлсэн бичиг баримт болохыг хэлж өгнө.

5. Лавлах утас

1. 9910-4966

2023.05.08-2023.05.19 өдрийг хүртэл (ажлын цагаар 09:00-13:00, 14:00-17:00)

2. Бусад үед (ажлын цагаар 09:00-13:00, 14:00-17:00)

11-320777 #124, #125

Жич: Тус хөтөлбөрийн бүртгэл, шалгалт явуулах зэргийг ЭСЯ дангаар хариуцдаг тул Монгол Япон төв, бусад байгууллагаас лавлахгүй байхыг анхааруулъя.

АСУУЛТ ХАРИУЛТЫН БУЛАН

Жил бүр хамгийн ихээр ирдэг асуултын хариултыг оруулав.

【Бүртгүүлж болох шалгуурын тухай】

Q1: Одоо Японд хувийн зардлаар их, дээд сурч байгаа бол Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт бүртгүүлж, шалгалт өгч болох уу?

A1: Болохгүй.

【Шалгалт болон сонгон шалгаруулалтын тухай】

Q2: Шалгалтын агуулга хэр хүнд вэ. Жишээлбэл, англи хэлний TOEFL, IELTS-ын хэдэн оноотой байвал шалгалтад тэнцэх боломжтой байх вэ?

A2: Өмнөх жилүүдийн шалгалтын материалын талаар доорх линкнээс үзэж болно.
<https://www.studyinjapan.go.jp/en/planning/scholarship/application/examination.html>

Тухайн жилийн нийт шалгалтад тэнцэгсдийн онооны дундажыг харж шийдвэрлэдэг тул TOEFL зэрэг англи хэлний шалгалттай дүйцүүлж үзэх боломжгүй.

Q3: Бичгийн шалгалт болон ярилцлагын шатанд тэнцсэн хариу авсан ч дараагийн шалгаруулалтаас буюу 12 сард тэнцээгүй гэсэн хариу авсан. Бичгийн шалгалт, ярилцлагын шалгалтад тэнцсэн байхад ийм хариу ирдэг үү?

A3: Нэгдүгээр шатны шалгаруулалт буюу бичгийн шалгалт, ярилцлагын шатанд тэнцсэн оюутны нэрийг тус ЭСЯ-наас Японы БШУЯ руу санал болгож явуулдаг. Түүний дараа Японы БШУЯ-наас хоёрдугаар шатны сонгон шалгаруулалт явуулж, эцсийн байдлаар шийдвэрлэдэг. Японы Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн элсэлтийн шалгалт зөвхөн Монголд төдийгүй дэлхийн улс, орнуудад зэрэг зохион байгуулагддаг ба бусад орнуудаас нэр дэвшсэн бүх оюутнууд дунд шалгаруулалт болно гэсэн үг юм. Иймд Монголд нэгдүгээр сонгон шалгаруулалтад тэнцсэн нь Японд суралцах эцсийн хариу болно гэж ойлгож болохгүй.